



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/161/НА-СТА-ТШЗ

| | |
|--|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2022 он</p> | <p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цог-Эрдэнэ Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdene.g@audit.gov.mn</p> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын дүгнэлт

| | |
|--|----|
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 5 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 6 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 7 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 9 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 11 |
| 3. Аудитын тайлан..... | 12 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 12 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 12 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 13 |
| 3.4 Материаллаг байдал | 13 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 13 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 14 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 15 |
| 3.8 Аудитын гол асуудал | 15 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 15 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... | 15 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 16 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 16 |
| 4. Аудитын илрүүлэлт | 16 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 17 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 17 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |
| БШУГ | Боловсрол, шинжлэх ухааны газар |

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ХҮҮХДИЙН 12
ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ж.САРАНТУЯА ТАНАА

2022.04.23 № 62
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбулган сумын Хүүхдийн 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхгүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|----|--|------------------|------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 53,561,660.16 | 49,254,931.16 |
| 2 | БАРАА МАТЕРИАЛ | 53,561,660.16 | 49,254,931.16 |
| 3 | Түүхий эд материал | | 1,721,900 |
| 4 | Эм боох материал | | 1,721,900 |
| 5 | Хангамжийн материал | 53,561,660.16 | 47,533,031.16 |
| 6 | Бичиг хэргийн материал | 148,500 | 213,500 |
| 7 | Аж ахуйн материал | 51,160,724.16 | 44,371,551.16 |
| 8 | Барилгын засварын материал | 727,600 | 2,177,000 |
| 9 | Хүнсний материал | 1,524,836 | 770,980 |
| 10 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,260,851,462.11 | 1,272,652,956.82 |
| 11 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,260,851,462.11 | 1,272,652,956.82 |
| 12 | Биет хөрөнгө | 1,209,664,962.15 | 1,221,511,456.86 |
| 13 | Барилга, байгууламж, орон сууц | 1,220,668,091 | 1,220,668,091 |
| 14 | Хуримтлагдсан элэгдэл | -40,688,936.4 | -61,033,404.6 |
| 15 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 50,748,392.36 | 45,083,900.63 |
| 16 | Хуримтлагдсан элэгдэл | -27,169,477.63 | -788,588.28 |
| 17 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 22,840,250.5 | 23,486,975.5 |
| 18 | Хуримтлагдсан элэгдэл | -17,384,307.68 | -6,556,467.39 |
| 19 | Ном | 650,950 | 650,950 |
| 20 | Биет бус хөрөнгө | 51,186,499.96 | 51,141,499.96 |
| 21 | Програм хангамж | 2,417,500 | 2,417,500 |
| 22 | Хуримтлагдсан элэгдэл | -1,191,000.04 | -1,236,000.04 |
| 23 | Бусад биет бус хөрөнгө | 49,960,000 | 49,960,000 |
| 24 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,314,413,122.27 | 1,321,907,887.98 |
| 25 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,314,413,122.27 | 1,321,907,887.98 |
| 26 | Засгийн газрын хувь оролцоо | 1,314,413,122.27 | 1,321,907,887.98 |
| 27 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 49,960,000 | 49,960,000 |
| 28 | Хуримтлагдсан үр дүн | 1,264,453,122.27 | 1,271,947,887.98 |
| 29 | Өмнөх үеийн үр дүн | 1,283,619,816.89 | 1,264,453,122.27 |
| 30 | Тайлант үеийн үр дүн | -19,166,694.62 | 7,494,765.71 |
| 31 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,314,413,122.27 | 1,321,907,887.98 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | өмнөх он | тайлант он |
|----|--|----------------|----------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 420,890,000 | 463,440,286.63 |
| 2 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 6,801,000 | 37,638,086.63 |
| 3 | Нийтлэг татварын бус орлого | 6,801,000 | 37,638,086.63 |
| 4 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,801,000 | |
| 5 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 6,801,000 | |
| 6 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 37,473,836.63 |
| 7 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 164,250 |
| 8 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 414,089,000 | 425,802,200 |
| 9 | Улсын төвлөрсөн төсвөөс | 330,268,800 | 331,491,100 |
| 10 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 330,268,800 | 331,491,100 |
| 11 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 210,000 | 847,300 |
| 12 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 210,000 | 847,300 |
| 13 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 83,610,200 | 93,463,800 |
| 14 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 83,610,200 | 93,463,800 |
| 15 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 440,056,694.62 | 455,945,520.92 |
| 16 | УРСГАЛ ЗАРДАЛ | 440,056,694.62 | 455,945,520.92 |
| 17 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 431,423,157.33 | 450,805,019.92 |
| 18 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 251,912,184 | 259,747,028.02 |
| 19 | Үндсэн цалин | 194,693,992 | 200,139,632.5 |
| 20 | Нэмэгдэл | 31,491,487 | 33,499,029.52 |
| 21 | Урамшуулал | 25,726,705 | 26,108,366 |
| 22 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 35,350,986 | 34,713,790.98 |
| 23 | Тэтгэврийн даатгал | 25,071,486 | 24,715,300 |
| 24 | Тэтгэмжийн даатгал | 2,569,900 | 2,349,790.98 |
| 25 | ҮОМШӨ-ний даатгал | 2,055,900 | 2,039,700 |
| 26 | Ажилгүйдлийн даатгал | 514,000 | 712,334.33 |
| 27 | Эрүүл мэндийн даатгал | 5,139,700 | 4,896,665.67 |
| 28 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 80,109,526.71 | 83,049,904 |
| 29 | Гэрэл, цахилгаан | 2,049,981.71 | 1,891,686 |
| 30 | Түлш, халаалт | 74,325,945 | 78,234,582 |
| 31 | Цэвэр, бохир ус | 3,733,600 | 2,923,636 |
| 32 | Хангамж, бараа материалын зардал | 2,062,450 | 3,032,620 |
| 33 | Бичиг хэрэг | 680,270 | 924,810 |
| 34 | Тээвэр, шатахуун | 120,000 | 37,500 |
| 35 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 661,200 | 482,600 |
| 36 | Ном, хэвлэл | 38,180 | |
| 37 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 168,500 |
| 38 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 562,800 | 1,419,210 |
| 39 | Нормативт зардал | 21,385,581 | 21,900,352 |
| 40 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 98,400 | 5,635,050 |
| 41 | Хоол, хүнс | 21,287,181 | 13,629,802 |
| 42 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 2,635,500 |
| 43 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,054,000 | 8,071,100 |
| 44 | Урсгал засвар | 2,054,000 | 8,071,100 |
| 45 | Томилолт, зочны зардал | 80,000 | |
| 46 | Дотоод албан томилолт | 80,000 | |
| 47 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,144,200 | 2,461,140 |
| 48 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,102,500 | 2,361,140 |
| 49 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 41,700 | 100,000 |

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|----|--|-----------------------|---------------------|
| 50 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,324,229.62 | 37,829,084.92 |
| 51 | Бараа үйлчилгээний бусад зардал | 141,110 | 345,000 |
| 52 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,143,840 | 8,811,743 |
| 53 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 34,039,279.62 | 28,672,341.92 |
| 54 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,633,537.29 | 5,140,501 |
| 55 | Бусад урсгал шилжүүлэг | 272,430 | 300,000 |
| 56 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 272,430 | 300,000 |
| 57 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 931,673.29 | |
| 58 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 931,673.29 | |
| 59 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 7,429,434 | 4,840,501 |
| 60 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,429,434 | 4,840,501 |
| 61 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | -19,166,694.62 | 7,494,765.71 |
| 62 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | -19,166,694.62 | 7,494,765.71 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---------------------------------------|---------------------------------|-------------------|--|
| 1 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 49,960,000 | 1,283,619,816.89 | 1,333,579,816.89 |
| 2 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 49,960,000 | 1,283,619,816.89 | 1,333,579,816.89 |
| 3 | Тайлант үеийн үр дүн | | -19,166,694.62 | -19,166,694.62 |
| 4 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 49,960,000 | 1,264,453,122.27 | 1,314,413,122.27 |
| 5 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 49,960,000 | 1,264,453,122.27 | 1,314,413,122.27 |
| 6 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 49,960,000 | 1,264,453,122.27 | 1,314,413,122.27 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | 7,494,765.71 | 7,494,765.71 |
| 8 | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 49,960,000 | 1,271,947,887.98 | 1,321,907,887.98 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | өмнөх он | тайлант он |
|----|--|----------------|---------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 414,089,000 | 425,802,200 |
| 2 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 414,089,000 | 425,802,200 |
| 3 | Улсын төвлөрсөн төсвөөс | 330,268,800 | 331,491,100 |
| 4 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 330,268,800 | 331,491,100 |
| 5 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 210,000 | 847,300 |
| 6 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 210,000 | 847,300 |
| 7 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 83,610,200 | 93,463,800 |
| 8 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 83,610,200 | 93,463,800 |
| 9 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 409,724,500 | 422,802,200 |
| 10 | УРСГАЛ ЗАРДАЛ | 409,724,500 | 422,802,200 |
| 11 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 401,175,092.71 | 417,661,699 |
| 12 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 253,135,500 | 259,547,219 |
| 13 | Үндсэн цалин | 195,917,308 | 199,539,632.5 |
| 14 | Нэмэгдэл | 31,491,487 | 33,899,220.5 |
| 15 | Урамшуулал | 25,726,705 | 26,108,366 |
| 16 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 34,211,800 | 34,913,600 |
| 17 | Тэтгэврийн даатгал | 23,932,300 | 24,715,300 |
| 18 | Тэтгэмжийн даатгал | 2,569,900 | 2,549,600 |
| 19 | ҮОМШӨ-ний даатгал | 2,055,900 | 2,039,700 |
| 20 | Ажилгүйдлийн даатгал | 514,000 | 712,334.33 |
| 21 | Эрүүл мэндийн даатгал | 5,139,700 | 4,896,665.67 |
| 22 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 80,109,526.71 | 83,049,904 |
| 23 | Гэрэл, цахилгаан | 2,008,175.71 | 1,891,686 |
| 24 | Түлш, халаалт | 74,367,751 | 78,234,582 |
| 25 | Цэвэр, бохир ус | 3,733,600 | 2,923,636 |
| 26 | Хангамж, бараа материалын зардал | 3,177,000 | 2,900,130 |
| 27 | Бичиг хэрэг | 793,000 | 441,210 |
| 28 | Тээвэр, шатахуун | 120,000 | 37,500 |
| 29 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 787,500 | 487,100 |
| 30 | Ном, хэвлэл | 102,300 | |
| 31 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 168,500 |
| 32 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,374,200 | 1,765,820 |
| 33 | Нормативт зардал | 22,908,166 | 21,431,446 |
| 34 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,048,150 | 7,022,700 |
| 35 | Хоол, хүнс | 21,399,416 | 12,875,946 |
| 36 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 460,600 | 1,532,800 |
| 37 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,569,000 | 9,520,500 |
| 38 | Урсгал засвар | 2,569,000 | 9,520,500 |
| 39 | Томилолт, зочны зардал | 80,000 | |
| 40 | Дотоод албан томилолт | 80,000 | |
| 41 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,504,200 | 4,587,200 |
| 42 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,254,200 | 4,487,200 |
| 43 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000 | 100,000 |
| 44 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,479,900 | 1,711,700 |
| 45 | Бараа үйлчилгээний бусад зардал | 209,000 | |
| 46 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,270,900 | 1,711,700 |
| 47 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,549,407.29 | 5,140,501 |
| 48 | Бусад урсгал шилжүүлэг | 188,300 | 300,000 |
| 49 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 188,300 | 300,000 |

| | | | |
|----|--|------------|------------|
| 50 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 931,673.29 | 893,396 |
| 51 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 931,673.29 | 893,396 |
| 52 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 7,429,434 | 3,947,105 |
| 53 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,429,434 | 3,947,105 |
| 54 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 4,364,500 | 3,000,000 |
| 55 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 4,364,500 | 3,000,000 |
| 56 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 4,364,500 | 3,000,000 |
| 57 | Дотоод эх үүсвэрээр | 4,364,500 | 3,000,000 |
| 58 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 4,364,500 | 3,000,000 |
| 59 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -4,364,500 | -3,000,000 |
| 60 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | | |
| 61 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 |
| 62 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 0 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|----|---|-------------|-------------|-------------|-------|
| 1 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 424,954,900 | 420,114,399 | (4,840,501) | 98.9 |
| 2 | УРСГАЛ ЗАРДАЛ | 424,954,900 | 420,114,399 | (4,840,501) | 98.9 |
| 3 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 424,654,900 | 419,814,399 | (4,840,501) | 98.9 |
| 4 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 260,151,900 | 259,547,219 | (604,681) | 99.8 |
| 5 | Үндсэн цалин | 199,633,300 | 199,539,633 | (93,668) | 100.0 |
| 6 | Нэмэгдэл | 35,815,600 | 33,899,221 | (1,916,380) | 94.6 |
| 7 | Урамшуулал | 24,703,000 | 26,108,366 | 1,405,366 | 105.7 |
| 8 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 34,913,600 | 34,913,600 | - | 100.0 |
| 9 | Тэтгэврийн даатгал | 24,715,300 | 24,715,300 | - | 100.0 |
| 10 | Тэтгэмжийн даатгал | 2,549,600 | 2,549,600 | - | 100.0 |
| 11 | ҮОМШӨ-ний даатгал | 2,039,700 | 2,039,700 | - | 100.0 |
| 12 | Ажилгүйдлийн даатгал | 509,900 | 712,334 | 202,434 | 139.7 |
| 13 | Эрүүл мэндийн даатгал | 5,099,100 | 4,896,666 | (202,434) | 96.0 |
| 14 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 83,943,300 | 83,049,904 | (893,396) | 98.9 |
| 15 | Гэрэл, цахилгаан | 2,463,500 | 1,891,686 | (571,814) | 76.8 |
| 16 | Түлш, халаалт | 77,379,800 | 78,234,582 | 854,782 | 101.1 |
| 17 | Цэвэр, бохир ус | 4,100,000 | 2,923,636 | (1,176,364) | 71.3 |
| 18 | Хангамж, бараа материалын зардал | 2,881,200 | 2,830,130 | (51,070) | 98.2 |
| 19 | Бичиг хэрэг | 95,400 | 371,210 | 275,810 | 389.1 |
| 20 | Тээвэр, шатахуун | 150,000 | 37,500 | (112,500) | 25.0 |
| 21 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 597,200 | 487,100 | (110,100) | 81.6 |
| 22 | Ном, хэвлэл | 60,300 | | (60,300) | - |
| 23 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 209,300 | 168,500 | (40,800) | 80.5 |
| 24 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,769,000 | 1,765,820 | (3,180) | 99.8 |
| 25 | Нормативт зардал | 23,945,500 | 20,654,146 | (3,291,354) | 86.3 |
| 26 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,245,400 | 6,245,400 | - | 100.0 |
| 27 | Хоол, хүнс | 16,167,300 | 12,875,946 | (3,291,354) | 79.6 |
| 28 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,532,800 | 1,532,800 | - | 100.0 |
| 29 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,520,500 | 9,520,500 | - | 100.0 |
| 30 | Урсгал засвар | 9,520,500 | 9,520,500 | - | 100.0 |
| 31 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,587,200 | 7,587,200 | - | 100.0 |

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|----|--|-------------|-------------|-------------|---------|
| 32 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,487,200 | 7,487,200 | - | 100.0 |
| 33 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 100,000 | 100,000 | - | 100.0 |
| 34 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,711,700 | 1,711,700 | - | 100.0 |
| 35 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,711,700 | 1,711,700 | - | 100.0 |
| 36 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 300,000 | 300,000 | - | 100.0 |
| 37 | Бусад урсгал шилжүүлэг | 300,000 | 300,000 | - | 100.0 |
| 38 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000 | 300,000 | - | 100.0 |
| 39 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 424,954,900 | 420,114,399 | (4,840,501) | 98.9 |
| 40 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 331,491,100 | 327,543,995 | (3,947,105) | 98.8 |
| 41 | Улсын төсвөөс санхүүжих | | | - | #DIV/0! |
| 42 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 331,491,100 | 327,543,995 | (3,947,105) | 98.8 |
| 43 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 93,463,800 | 92,570,404 | (893,396) | 99.0 |
| 44 | Орон нутгийн төсвөөс | 93,463,800 | 92,570,404 | (893,396) | 99.0 |
| 45 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | - | 100.0 |
| 46 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.0 |
| 47 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 26 | 26 | - | 100.0 |
| 48 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 49 | Гүйцэтгэх ажилтан | 10 | 10 | - | 100.0 |
| 50 | Үйлчлэх ажилтан | 15 | 15 | - | 100.0 |
| 51 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 150 | 150 | - | 100.0 |
| 52 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА | 150 | 150 | - | 100.0 |
| 53 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 150 | 150 | - | 100.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг /

| № | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|--|------------|
| 1 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 847,300.00 |
| 2 | УРСГАЛ ЗАРДАЛ | 847,300.00 |
| 3 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 847,300.00 |
| 4 | Бичиг хэргийн зардал | 70,000.00 |
| 5 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 777,300.0 |
| 6 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 847,300.00 |
| 7 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 847,300.00 |
| 8 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 847,300.00 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрдэнэбулган сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэг нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, хуульд заасан хугацаанд мэдээлж хэвшихтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21 -ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д “бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох”, 5.1.2-д “хэл яриа, сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх, хүрээлэн байгаа орчин, юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох”, 5.1.3-д “хүүхдийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэн дүрслэн зурах, урлан бүтээх, дуулж хөгжимдөх, бүжиглэх чадвар эзэмшихэд туслах”, 5.1.4-д “хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, БШУЯ-ны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааг, танхим болон зайнаас чанартай зохион байгуулж, эцэг, эх асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлэх” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгжтэй тул үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 424.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 2.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 7.5 сая төгрөгөөр буюу 0.6 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | Хувь |
|---|----------------|-----------------|------------|--------------|
| Бараа материал | 53.6 | 49.3 | (4.3) | 92.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,260.9 | 1,272.7 | 11.8 | 100.9 |
| Нийт хөрөнгө | 1,314.4 | 1,321.9 | 7.5 | 100.6 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,314.4 | 1,321.9 | 7.5 | 100.6 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,314.4 | 1,321.9 | 7.5 | 100.6 |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл 8 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 53.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 29.6 сая төгрөг, аймгийн БШУГ-аас 0.16 сая төгрөгийн хөрөнгө шилжиж ирсэн нийт 29.8 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 34.1 сая төгрөгийн зарцуулалт гарч, 49.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 0.9 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,260.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 3.0 сая төгрөг, үлдэгдэл өртөггүй хөрөнгийг данс бүртгэлээс хасч дахин үнэлж шинээр бүртгэсэнтэй холбоотойгоор 37.5 сая төгрөг нийт 40.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 28.7 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 1,272.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 7.5 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | / сая.төгрөгөөр/ | | |
|---|------------------|--------------|-------------|
| | Өмнөх он | Тайлант он | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/орон нутгийн төсөв/ | 83.6 | 93.5 | 9.9 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/улсын төсөв/ | 330.3 | 331.5 | 1.2 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.2 | 0.8 | 0.6 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | - | 37.5 | 37.5 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 6.8 | 0.2 | -6.6 |
| Үйл ажиллагааны орлого | 420.9 | 463.4 | 42.5 |
| Цалин, шимтгэлийн зардал | 287.3 | 294.5 | 7.2 |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 145.4 | 156.3 | 10.9 |
| Урсгал шилжүүлэг | 8.6 | 5.1 | -3.5 |
| Үйл ажиллагааны зардал | 441.3 | 455.9 | 14.6 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | (20.4) | 7.5 | 27.9 |

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 11.1 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн нь тогтмол зардал нэмэгдсэнтэй холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 490.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 45.1 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 445.3 сая төгрөгөөр хянаж баталсан байна. Харин тайлант онд батлагдсан төсвийн дүнг 4.6 хувиар буюу 20.4 сая төгрөгөөр бууруулан тодотгожээ. Төсөв бууруулсан шалтгаан нь ковид 19 цар тахал холбоотойгоор хүүхдийн хоолны зардал хэмнэгдэж төвлөрүүлсэнтэй холбоотойгоор буурсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 424.9 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 420.1 сая төгрөгийг зарцуулж, 4.8 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлж, тайлант онд батлагдсан төсвийг 1.1%-иар хэмнэж төсвийн хэмнэлтийг бий болгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн БШУГ-аас 0.84 сая төгрөгийн орлого санхүүжилт олгосон ба ковид19 цар тахалтай холбоотойгоор цэцэрлэгийн байр болон гадна талбайг ариутгал халдваргүйтгэл хийлгэхэд 0.77 сая төгрөгийг, бичиг хэргийн зардалд 0.07 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Боловсролын тухай хуульд 2021 оны 07 дугаар сарын 02, 11 дүгээр сарын 12, 12 дугаар сарын 17-ны байдлаар 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна.

Мөн тус байгууллага нь дээд шатны төсөв захирагчид төсөвт зохицуулалт хийх хүсэлт гаргасны дагуу урсгал зардлаас 6.5 сая төгрөгөөр 2021 оны 08 дугаар сард цэцэрлэгийн гадна талын пасадын засвар үйлчилгээг “Өрнөх цэнхэр” ХХК-иар гүйцэтгүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 80 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 424.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 98.9 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд орон тоо нэмэгдүүлээгүй, шагнал урамшуулал олгоогүй, автомашин худалдан аваагүй байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээллэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэг нь 2021 онд нийт 93.5 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 93.5 сая төгрөгийн 139 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 2.7% буюу 1.2 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт нь холбогдох шалгуурт тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчилтэй асуудал илрээгүй болно.

-----oO-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа зөрчлийн утга | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | | |
|--|-------------------------------------|--|----------------------|------------|-----------|-----|---------------|-----|-----------------|------------|----------|----------|--|
| | | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | |
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | | | |
| 1 | | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | | |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | | | |
| 1 | Хүүхдийн 12 дугаар цэцэрлэг | МУЗГ-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилт 2.7% буюу 1.2 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна | 1 | 1.2 | | | | | 1 | 1.2 | | | |
| 2 | | 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн | 1 | - | | | | | | | 1 | - | |
| Дүн | | | 2 | 1.2 | | | | | 1 | 1.2 | 1 | - | |
| Нийт дүн | | | 2 | 1.2 | | | | | 1 | 1.2 | 1 | - | |